

ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

2022.11.03.

Улаангом хот

1. Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг тус тус үндэслэн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.
2. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээд нь Төсвийн шууд захирагчийн болон Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайланг УСНББОУС, СТОУС, НББОУС болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.
3. Санхүүгийн тайлангийн аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9-д заасан цаглабарт хугацаанд гүйцэтгэнэ.
4. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь дараах материалыг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү. Үүнд:
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
 - Татварын тодорхойлолт;
 - Нийгмийн даатгалын тодорхойлолт;
 - ШШГЕГ-ын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;
 - ММНБИ-ын тодорхойлолт;
 - Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
 - Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
 - Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
 - Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/

Зөвлөх үйлчилгээтэй холбоотой нэмэлт мэдээллийг 70453317 дугаар утсаар авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2022 оны 11 дугээр сарын 11-ний өдрийн 11.00 цагаас өмнө цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ үү.

Хаяг: Увс аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 3 дугаар давхар 304 тоот өрөө, цахим хаяг uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газар

